

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИСС

Шүүх болон цагдаагийн байгууллага дээр хэрэгсэхгүй болгогдсон эрүүгийн хэргийн талаар судалгаа хийх удирдамж

2001.04.09

1. 2000 онд нийслэлийн шүүх, дүүргүүдийн шүүх, мөрдөн байцаах газар, дүүргүүдийн цагдаагийн мөрдөн байцаах тасаг, хэрэг бүртгэх алба, Эрүүгийн цагдаа, Эдийн засгийн цагдаагийн албад дээр шалгагдаж байгаад хэрэгсэгдэхгүй болгогдсон хэдэн эрүүгийн хэргийн хэдэн сэжигтэн, яллагдагч нарыг хорьж, эрхийг нь хохироосон, хохирлыг хэрхэн яаж барагдуулсаныг судалж, дүгнэлт гаргахад судалгааны зорилго оршино.
2. Судалгааг хэрэгсэхгүй болгогдсон хэрэг нэг бүртэй танилцаж, судалгаа эвах, хавсралтанд орсон асуултанд хэргийн холбогдох тогтоол, бичиг баримтаас гүүвэрлэн авч хариулах замаар хийнэ.
3. Эрүүгийн хуулийн 127-р зүйлийн хэрэгт шалгагдаж байсан хүмүүсийн <увьд иргэд хоорондын болон ломбардын зээлийн гэрээтэй холбоотой асуудалд (олбогдон шалгагдсан эсэхийг онцлон анхаарна.
4. Тухайн шүүх, цагдаагийн байгууллага дээр хэрэгсэгдэхгүй болгогдсон орэг бүрийг бүртгэлтэй нь хүлээн авч, эргүүлж тулгалт хийн хүлээлгэн өгнө.

UIN.MN
СУДАЛГААНЫ САН

ИЛТГЭХ ХУУДАС

2001.04.17

Улаан баатар хот
Нийслэлийн шүүхээс 2000 онд
хэрэгсэхгүй болгосон хэргүүдийг
судалсан тухай

Нийслэлийн болон дүүргийн шүүхүүдээс 2000 он, 2001 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн хэргүүдийг нэг бүрчлэн үзэж хавсралт хүснэгтээр судалж үзсэн болно.

2000 онд Нийслэлийн болон харъяа дүүргүүдийн шүүхийн хэмжээнд 93 хүнд холбогдох 54 хэргийг хэрэгсэхгүй болгож, таслан шийдвэрлэх цагаатгах тогтоол гаргаж шийдвэрлэжээ. Үүнээс 43 хүнд холбогдох хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, 29 хүнд холбогдох хэргийг хохирогч шүүгдэгчтэй эвлэрэн хэлэлцсэн, 14 хүнд холбогдох хэргийг гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүй, 4 хүнд холбогдох хэргийг яллагч яллахаас татгалзсан, 3 хүнд холбогдох хэргийг хөөн хэлэлцэх хугацаа хэтэрсэн буюу яллагдагч нас барсан гэсэн үндэслэлээр тус тус хэрэгсэхгүй болгожээ. Иймээс 93 хүний 65,5 хувьд нь 61 хүнд үндэсгүйгээр ял тулгаж хилсээр ял сонсгож, эрүүгийн хариуцлагад татуулахаар шүүхэд шилжүүлж байжээ гэж үзэх үндэстэй байна.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 98 -р зүйлийн 1 дэх хэсэгт заасан бусдын биед санаатайгаар хөнгөн гэмтэл учруулсан гэсэн үндэслэлээр ял төлөвлөж ирсэн 29 хүний хэргийг шүүгдэгч хохирогчтой эвлэрэн хэлэлцсэнээр хэрэгсэхгүй болгосон байна. Тэдний 6 нь хэрэг бүртгэх болон мөрдөн байцаалтын шатанд ямар нэг хэмжээгээр албадан саатуулагдаж, цагдан хрригдож байсан байна.

Нийт хэрэг/Мхэрэгсэхгүй болгогдсон 93 хүний 13 хүн нь 2 - 67 хоногоор бүгд 224 хоног цагдан хоригдсон судалгаа гарч байна. «Тухайлбал Баянзүрх дүүргийн иргэн Б. Жаргалсайхан бусдын биед хүнд гэмтэл учруулсан хэрэгт холбогдон, хэрэг 4 жил сунжирч 67 хоног цагдан хоригдож шүүхэд шилжиж ирсэн боловч хэрэг нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр цагаатгагдаж байсан байна.1

2001 оны эхний улиралд Баянзүрх дүүргийн 3 хүнд холбогдох бусдын өмчийг бага хэмжээтэйгээр ашиглан шамшигдуулсан хэргийг шүүгдэгчид нь 16 насанд хүрээгүй гэдэг үндэслэлээр, Чингэлтэй дүүргийн шүүх Б. Отгонбилэгт холбогдох хэргийг иргэний гэрээ хэлцэлтэй холбоотой, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж үзэж хэрэгсэхгүй болгосон байна.

Цаашид шүүхээр хэрэг нь хэрэгсэхгүй болгогдсон тохиолдолд тухайн этгээд хэд хоног цагдан хоригдож байсныг нь статистик мэдээндээ тусгадаг болгох шаардлагатай байна.

Ер нь албадан саатуулагдаж, цагдан хоригдож байгаад хэрэгсэхгүй болгосон тохиолдлыг прокурорын байгууллагаар дамжуулан улсын хэмжээнд нэгтгэн бүртгэж, албан ёсны статистик мэдээ гаргаж авдаг журам тогтоох санал оруулж байна.

ИЛТГЭХ ХУУДАС

2001.04.24

Улаан баатар хот

Улсын Мөрдөн Байцаах Газрын төв аппарат болох хэлтсүүдэд шалгаж хэрэгсэхгүй болгосон хэргийг танилцаж судалсан дүнгийн тухай

Хүний Эрхийн Үндэсний Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу тус мөрдөн байцаах газрын 2, 3, 4 -р хэлтэст 2000 онд болон энэ 2001 оны нэгдүгээр улиралд мөрдөн байцаалт явуулаад хэрэгсэхгүй болгосон хэргүүдийг нэг бүрчлэн үзэж, хүний эрхийг зөрчсөн байдлыг, түүний дотор сэжигтэнээр албадан саатуулсан, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан үндэслэлийг судлан үзлээ.

2000 онд 2, 3, 4, 5 -р хэлтсүүд ажилласны Хүүхдийн хэрэг мөрддөг хэлтэс татан буугдаж, 2, 3, 4 -р хэлтсүүд одоо ажиллаж томоохон, онц ноцтой хэрэг болон цэрэг цагдаа, хуулийн байгууллагын ажилтнаас үйлдсэн хэргийг мөрдөн шалгадаг юм байна.


Танилцаж судлах ажлын зорилгоо тус Мөрдөн байцаах газрын дарга Ж. Бумнамжидад танилцуулж зөвшөөрөл авч, хэлтсийн дарга М. Энх - Амгалан, Х. Эрдэнэбат, Т. Сайнжаргал нартай ярилцан хэргүүдийг авч танилцаж судалсан юм.

Тус газрын жил, улирлын мэдээгээр хэрэгсэхгүй болгосон хэрэг 2000 онд 126, 2001 оны нэгдүгээр улиралд 24 байх ёстой боловч 2000 онд хэрэгсэхгүй болгосон 299 холбогдогч, яллагдагчтай 177, 2001 оны I улиралд хэрэгсэхгүй болгосон 28 холбогдогч, яллагдагчтай 19 хэрэг үзэж судлав.

Прокурорт хянахаар татсан цөөн тооны хэрэгсэхгүй болгосон хэрэг байгаа учир судалж танилцаагүй болно.

Дээрх хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн ихэнхийг Эрүүгийн цагдаагийн газар, түүний Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх хэлтэс, алба, зарим аймаг, дүүргүүдийн Цагдаагийн хэлтсээс эрүү үүсгэн хэрэг бүртгэлт явуулсан хэргүүд эзэлж байв.

2000 онд хэрэгсэхгүй болгосон хэргийн 53 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, 33 хүнийг сэжигтэнээр албадан саатуулсан байна. Энэ оны 1-р улиралд хэрэгсэхгүй болгосон хэргийн 17 хүнийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, 1 хүнийг сэжигтэнээр албадан саатуулжээ. Эдгээр сэжигтэнээр албадан саатуулагдсан, цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүс нь дээрх хэрэгсэхгүй болгосон хэргийн нийт холбогдогч, яллагдагчдын 31,8 % -ийг эзэлж байна.



Дээрх сэжигтэнээр албадан саатуулагдсан, цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан хүмүүсээс 56 хүний хэргийг гэмт хэрэг гараагүй буюу гэмт хэрийн бүрэлдэхүүнгүй гэдэг үндэслэлээр хэрэгсэхгүй болгосон, 33 хүний хэргийг гэмт хэрэг үйлдсэнийг тогтоож нотолж чадахгүйгээс хэрэгсэхгүй болгожээ. Энэ нь хүний эрхийг ноцтой зөрчиж байгаа илрэл юм. Эд нараас нэр бүхий 16 хүнийг 30 хоногоос 144 хоног хүртэл хугацаагаар цагдан хорьсон байна. Зарим жишээ баримтыг дурдвал :

Иргэн Ж. Зоригтыг эцгийгээ зодож хүнд гэмтээснээс тэр нь амь насаа алдсан хэрэгт сэжиглэн 1998 оны 9 -р сарын 2 -ноос 1999 оны 1 -р сарын 20 хүртэл 138 хоног цагдан хорьж мөрдөөд, энэ хэрэгт үүнээс гадна 3 хүнийг

6- 1 8 хоног хорьж мөрдөн байцаалт явуулаад тогтоож нотолж чадалгүй уг хэргийг 2000 оны 6 -р сарын 20 -нд хяналтын прокурор Л. Сарангэрэл хэрэгсэхгүй болгосон байв.

Мөрдөн байцаагч Б. Одбаяр хүний амь нас бусниулсан хэрэгт сэжигтэн Н. Эрдэнэсүрэнг 1999 онд 13 хоног, 2000 онд 61 хоног бүгд 74 хоног, О. Алёшаг 2000 онд 58 хоног, иргэн Ц. Бурмааг бусдын амь насанд аюултай байдал тохиолдоод байхад тусламж үзүүлээгүй гэж сэжиглэн 1999 онд 12 хоног, 2000 онд 63 хоног бүгд 75 хоног тус тус цагдан хорьж шалгаад, тогтоож нотолж чадаагүйгээс прокурор ялын дүгнэлт бичиж, яллахаас татгалзсан учир уг хэргийг 2001 оны 1 -р сарын 22 -нд хэрэгсэхгүй болгосон байна.


Мөн спиртны хордлогоор зүрхний дутагдалд орж нас барсан хүний хэрэгт иргэн Б. Хүрэл - Эрдэнийг сэжиглэн 2000 оны 11 -р сарын 9 -нөөс 12 -р сарын 23 хүртэл 44 хоног цагдан хорьж, уг хэргийг мөрдөн байцаагч Г. Лхачинжав 2001 оны 1 -р сарын 9 -нд хэрэгсэхгүй болгосон байна.

Иргэн Д. Сайнбаярыг бусдыг санаатай алсан хэрэгт сэжиглэн 46 хоног цагдан хорьж шалгаад хохирогч өөрийнхөө амийг хорлосон гэж тогтоож, уг хэргийг мөрдөн байцаагч Х. Чекара 2001 оны 1 -р сарын 28 -нд хэрэгсэхгүй болгожээ.

Д. Төмөрбаатар 2000 оны 3 -р сарын 16 -нд сэжигтэйгээр нас барсан хэрэгт Төв аймгийн Цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаагч н. Батбаатар эрүү үүсгэн шалгаж Д. Соёл - Эрдэнийг 144 хоног, Ц. Жамьянг 54 хоног, Л. Лооёог 32 хоног тус тус цагдан хорьж мөрдөн байцаалт явуулаад эцэст нь мөрдөн байцаагч Х. Чекара хохирогч согтуугаар өндөр шатнаас унаж нас барсан гэсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгожээ.

Иргэн Б. Баатарсүрэнг хүн амины хэрэгт сэжиглэн 2000 оны 8 -р сарын 9 —нөөс эхлэн 89 хоног хорьж мөрдөн хэрэг үйлдсэнийг нотлон тогтоож чадалгүй мөрдөн байцаагч Э. Лхагвадорж 2000 оны 11 -р сарын 24 -нд хэрэгсэхгүй болгосон байна.

ОХУ-ын иргэн М. А. Дамба иргэн Д. Бадарчийн олон сая төгрөгийн зүйлийг итгэл найдвар алдаж ашигласан, Д. Бадарч өөрөө хуурамч бичиг баримт үйлдсэн, залилан мэхэлсэн гэсэн сэжиглэлээр 1996 оноос эрүүгийн хэрэг үүсгэн шалгах явцад Д. Бадарчийг 40 хоног, М. А.



Дамбыг 58 хоног цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, мөрдөн байцаалт явуулаад шүүхэд шилжүүлсэн боловч шүүх мөрдөн байцаалтанд буцаасны эцэст 2000 оны 11 -р сарын 10 -нд уг хэргийг гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэж мөрдөн байцаагч С. Цогтбаатар хэрэгсэхгүй болгожээ.

Баянзүрх дүүргийн прокурорын хяналтын прокурор Г. Уранцэцэгт холбогдох хэрэгсэхгүй болгосон хэргийг хянахад тэрээр иргэн

Н. Оюунцэцэгийг бусдаас авсан зээлээ хугацаанд нь өгөөгүй, дуудсан цагт ирээгүй гэж сэжигтэнээр цагдан хорьсоныг ар гэрийнхэн нь ингэж хорьсноос цус харвахад хүргэсэн гэж гомдол гаргаж 7 хоног хориод байхад нь суллуулсан байна. Ийм ноцтой зөрчил гаргасан хяналтын прокурор Г. Уранцэцэгт Улсын ерөнхий прокурор 3 сарын хугацаагаар цалинг 20 хувиар бууруулж сахилгын арга хэмжээ авч байжээ.

Энэ мэтээр гэм буруугүй иргэнийг янз бүрийн хэрэгт сэжиглэн хорьж мөрдөх явдал жирийн үзэгдэл болсон байна.

Зарим мөрдөн байцаагч нар ярихдаа гэмт хэрэг үйлдсэн байж болох сэжигтэй байгааг хорьж мөрдөн байцаалтаар тогтоохоос өөр арга байхгүй шүү дээ. Зарим сэжигтэн этгээд оргон зайлахыг завдсан учир хорьж мөрдсөн гэж тайлбарлаж байлаа.

Эрүүгийн хуулийн 127 -р зүйлд заасан гэмт хэрэгт сэжиглэн зээлийн гэрээ хэлцэлтэй холбоотой иргэний хэргийн зөрчилд 20 хэрэгт 26 хүнийг холбогдуулан шалгаж, үүнээс 6 хүнийг цагдан хорьж, 5 хүнийг сэжигтэнээр албадан саатуулж мөрдөн шалгаад нотолж чадаагүй буюу ихэнх нь гэмт хэрэг биш болох нь нотлогдож хэрэгсэхгүй болгосон байлаа.

Дээрх хорьж мөрдөөд хэрэгсэхгүй болгосон хэргийг хуулийн зүйл ангиар авч үзвэл :

Эрүүгийн хуулийн 86 -р зүйлд заасан хүн амины ноцтой хэрэгт 25 хүнийг, 90 -р зүйлд заасан бусдад хүнд гэмтэл учруулсан хэрэгт 9 хүнийг, мөн хуулийн 292 -р зүйлд заасан хэрэгт 8, 127 -р зүйлд заасан хэрэгт 6 хүнийг тус тус цагдан хорьж мөрдөөд хэрэгсэхгүй болгосон байлаа.

Танилцаж судалсан хэрэгсэхгүй болгосон хэргийн тоо мэдээнд заасан тооноос их байгааг лавлахад урд онуудад түдгэлзүүлсэн, хэрэгсэхгүй болгосон хэргийг сэргээж шалгаад хэрэгсэхгүй болгосон, прокурорт шилжүүлснийг прокурор хянаад хэрэгсэхгүй болгосон зэрэг шалтгаантай хэргүүд ороогүй гэж тайлбарлаж байлаа.

Хойшид санал болгох нь :

Хүний эрх зөрчиж буй дээрх илрэлийг багасгах, давтан гаргуулахгүй байлгах талаар холбогдох арга хэмжээ авахуулж, уг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажил зохиолгохоор Мөрдөн байцаах газрын удирдлагад зөвлөмж бичих нь зүйтэй.

Судалгааны материалыг хавсаргав.

ИЛТГЭХ ХУУДАС

2001.04.20

Улаан баатар хот

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөрдөн байцаах тасаг болон Цагдаагийн хэлтэст хэрэгсэхгүй болгосон хэргийн талаар судалгаа хийсэн тухай

Нийслэлийн Чингэлтэй дүүргийн Мөрдөн байцаах тасаг болон Цагдаагийн хэлтэст 2000 он, 2001 оны 1 дүгээр улиралд хэрэгсэхгүй болгосон хэргийн талаар судалгааг 2001 оны 4 -р сарын 16, 17 -нд хийв.

3. Мөрдөн байцаах тасагт хийсэн судалгааны талаар

Мөрдөн байцаах тасагт 2000 онд 167 хэрэг, 2001 оны 1 -р улиралд 39 хэргийг тус тус хэрэгсэхгүй болгосныг хэргийн материалтай нэг бүрчлэн танилцаж судалгааг авлаа. 2000 хэрэгсэхгүй болгосон 167 хэргээс 26 хэргийн 35 холбогдогчийг, 2000 онд хэрэгсэхгүй болгосон 39 хэргээс 6 хэргийн 9 холбогдогчийг тус тус сэжигтнээр албадан саатуулсан буюу цагдан хорьсон байна.

2000 онд Эрүүгийн хуулийн 123³ -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 7 хүн, 127 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 7 хүн, 239 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 2 хүн, 98; 99 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 6 хүн,

175-р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 1 хүн, 90 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 1, 125 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 3 хүн, 112 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 2 хүн, 131 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 2, 138 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 1 хүн, 124 -р зүйлд 3 хүнийг тус тус албадан саатуулсан буюу цагдан хорьжээ.

2001 онд Эрүүгийн Хуулийн 98 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 4 хүн, 127—р зүйлд 3 хүн, 124-р зүйлд 1, 90-р зүйлд 1 хүн тус тус албадан саатуулагдсан, цагдан хоригдсон байна.

Хэргийг мөрдөн байцаах шатанд хэрэгсэхгүй болгосон үндэслэлүүд нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, нотлогдож тогтоогдоогүй, субъектив санаа зорилго йайхгүй, гэмт хэргийн шинжийг хэлбэрийн төдий агуулсан, иргэний журмаар шийдэгдэх, хэргийн хохирогч болон холбогдогч эвлэрсэн эсвэл тохиролцсон, хохирогчийн буруутай үйл ажиллагаа нөлөөлсөн буюу хохирогч гомдолгүй байгаа асуудлууд байна.

Албадан саатуулах хугацааг 24 - 72 цаг хэтрүүлсэн тохиолдол 2000 онд 6, цагдан хорьсон буюу албадан саатуулсныг өөрчилж зогсоосон хугацаа нь мэдэгдэхгүй байгаа тохиолдол 2000, 2001 онд 8 байна.

Иргэний журмаар шийдэгдэх хэргийг ялгаж салгахгүйгээр эрүүгийн хэрэг үүсгэсэн, түүгээр ч барахгүй холбогдогч болон хохирогч хоёрын хооронд албан есны гэрээтэй, холбогдогч

төлбөрийнхөө ихэнх хэсгийг төлсөн байхад түүнийг цагдан хорьсон, албадан саатуулсан тохиолдол 3 - 4 удаа гарсан байна. Иргэн ЦЭнхжаргал гэгчийг (гэрээтэй) Эрүүгийн хуулийн 127³-р зүйлд заасан гэмт хэрэгт юлбогдуулан 1995 оны 4 -р сарын 19 -нд эрүүгийн хэрэг үүсгэж, бараг 5 жилийн дараа 2000 оны 3 -р сарын 2 -нд уг хэргийг хэрэгсэхгүй болгосон, энэ хугацаанд 50 хоног цагдан хорьж эрхийг нь зөрчсөн ноцтой баримт байна. Иргэн Д. Махвал гэгч эхнэртэйгээ гэрлэлтээ цуцлахаас өмнө хамтран өмчлөх дундын өмчөө захиран зарцуулах эрхтэй байхад нь түүнд холбогдуулан Эрүүгийн хуулийн 123³-р зүйлд заасан эрүүгийн хэрэг үүсгэж албадан саатуулж, цагдан хорьсон байх бөгөөд ийнхүү саатуулсан буюу хорьсон хугацааг хэргийн материалаас үзэхэд мэдэгдэхгүй байна. Энэ хэргийг 2000 оны 1 -р сарын 26 -нд үүсгэж 2000 оны 11 -р сарын 27 —нд хэрэгсэхгүй болгожээ.

Эдгээрээс дүгнэлт хийж үзэхэд, мөрдөн байцаагч үйл ажиллагааг хялбарчлахын тулд хэрэгт холбогдогчийг зөвхөн хохирогчийн шаардсанаар олон цөөн хоног цагдан хорьж, албадан саатуулж хүний эрхийг бүдүүлгээр зөрчдөг явдал ажиглагдаж байна.

4. Хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгосон хэргийн талаар хийсэн судалгааны тухай

Чингэлтэй дүүргийн Цагдаагийн хэлтэст 2000 онд 99 хэрэг, 2001 оны 1 -р улиралд 13 хэрэг хэрэгсэхгүй болгосныг хэргийн материалтай нэг бүрчлэн танилцаж судалгаа гаргав.

2000 онд хэрэгсэхгүй болгосон 99 хэргээс 12 хэргийн 12 холбогдогчийг албадан саатуулжээ. 2001 онд хэрэгсэхгүй болгосон 13 хэргийн холбогдогчдыг албадан саатуулаагүй байна.

2000 онд Эрүүгийн хуулийн 123 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 5 хүн, 98, 99 -р зүйлд 5 хүн, 125 -р зүйлд 1 хүн, 86 -р зүйлд заасан гэмт хэрэгт холбогдсон 1 хүнийг албадан саатуулжээ.

Хэргийг хэрэгсэхгүй болгосон үндэслэлүүд дээрх мөрдөн байцаах ажиллагааны явцад хэрэгсэхгүй болгосон хэргүүдийнхтэй адил байна.

ИЛТГЭХ ХУУДАС

2001.04.24

Улаан баатар хот

Шалгалтыг ахлах референт Ж.Элбэгсайхан зохих удирдамжийн дагуу Баянгол дүүрэг болон Төмөр зам дахь Цагдаагийн хэлтсүүдэд 2001 оны 16-наас 23-ны хооронд хийв. Шалгалтыг хэлтсүүдийн мөрдөн байцаах тасаг болон тоо, бүртгэлийн албанд байгаа хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн материалтай танилцах, холбогдох ажилтнуудаас тайлбар авах, бүртгэл, мэдээ, тайлантай танилцах аргаар явуулав.

Нэг. Баянгол дүүргийн Цагдаагийн хэлтэст хийсэн шалгалтын талаар

Тус хэлтсийн орлогч дарга Ганбаатар, тоо бүртгэлийн эрхлэгч Норовсүрэн нартай уулзаж мөрдөн байцаалт болон хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн материалтай танилцав.

Танилцсан хэргийн материалаас үзэхэд мөрдөн байцаалт болон хэрэг бүртгэлтийн явцад 2000 он болон 2001 оны нэгдүгээр улиралд хэрэгсэхгүй болгосон хэрэгт сэжигтнээр албадан саатуулсан, сэжигтнээр цагдан хорьсон болон яллагдагчаар цагдан хорьсон хүний тоо, хэргийг хэрэгсэхгүй болгосон эрх зүйн үндэслэлийг дараахь хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

№	Асуулт	2000 он	2001 он	Бүгд
1	Танилцсан хэргийн тоо:			
1.1	мөрдөн байцаалтаар хэрэгсэхгүй болсон хэрэг	128	38	166
1.2	хэрэг бүртгэлтээр хэрэгсэхгүй болсон хэрэг	174	26	200
2	Эдгээр хэрэгт холбогдсон нийт хүний тоо	355	78	433
3	Хэрэгт холбогдсон хүмүүсээс сэжигтнээр албадан саатуулагдсан, цагдан хоригдсон хүний тоо	87	24	111
	Үүнээс:			
3.1	Хэрэг нь ЭБШХ-ийн 6.1-ээр хэрэгсэхгүй болсон хүний тоо	50	13	63
3.2	Хэрэг нь ЭБШХ-ийн 196.2-оор хэрэгсэхгүй болсон хүний тоо	21	4	25
3.3	ЭХ-ийн 127-р зүйлд заасан хэргээр	15	3	18

Мөрдөн байцаалтаар хэрэгсэхгүй болсон 2000 оны 181 холбогдогчтой 128 хэргийн материал үзэхэд 87 хүн (холбогдогчдын 48 хувь), 2001 оны 52 холбогдогчтой 38 хэргийг үзэхэд 24 хүнийг (46 хувь) албадан саатуулж, цагдан хорьсон нь анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл, тус цагдаагийн хэлтсийн үйл ажиллагаанд эдгээр арга хэмжээг хавтгайруулан хэрэглэдэг практик ажиглагдаж байна.

39 Хэрэгсэхгүй болгосон хэргийн материалаас үзэхэд 14-өөс дээш хоногоор албадан саатуулсан ба цагдан хорьсон хүн 2000 онд 15, 2001 онд 4 байна. Үүнд:

№	Хэргийн №	Хоригдсон хүн	ЭХ-ийн зүйл	Хоног	Хэрэг хэрэгсэхгүй болсон ЭБШХ-ийн үндэслэл
1	023165	Буяндэлгэрийн Лууша	90-2	48	6-1: гадны нөлөөгүй
2	024599	Сүхийн Ганбаатар	127-2	16	6-1: залилан мэхлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, 1 сая төгрөгийн зээлээ МБ-ын үед барагдуулсан
3	20024215	Жүгдэрийн Одхүү	112-3	25	196-2,197: гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдоогүй
4	925844	Сүмъяагажавын Ариунсанаа	127-3	36	196-2,9-1: 1.2 сая төгрөг залилан авсан нь тогтоогдоогүй, иргэний журмаар шийдэх асуудал
5	024106	Лувямжавын Эрдэнэсанаа	90-1	21	196-2:
6	᠒᠐᠐238 95	Оросоохүүгийн Баяраа	125-1	16	6-1,197:
7	᠒᠐0433 4	Гомбосүрэнгийн Дамдинсүрэн	123-3	17	196-2: 1.25 сая төгрөгийн хулгай тогтоогдоогүй
8	᠒᠐0239 80	Мөнхөөгийн СүхОчир	125-1	31	6-1: хохирол бага, хохирлоо арилгасан
9	023145	Солномпилийн Энхтайван	127-3	46	196-2: 7.3 сая төгрөгийг залилан авсан нь тогтоогдоогүй, анх тодорхой зориулалтаар авч зарцуулсан
10	᠒᠐0240 87	Түндэвийн Гантөмөр	123-3	17	196-2,197: гэмт үйлдэлд холбоотой нь тогтоогдоогүй
11	024380	Лувъяагийн Мөнхсайхан	98-1	22	6-4,197: эвлэрсэн
12	024286	Ляплогжийн Энхбүрэн	99-1	24	5-2,197: хор аюул бага
13	024285	Паламын Батчимэг	112-2	15	196-2: хүчиндсэн нь тогтоогдоогүй
14	926822	Марушийн Баярсайхан	127-1, 226	19	196-2: 926286 төгрөгийн асуудлыг иргэний журмаар шийдэх шаардлагатай
15	831772	Ламлинсүрэнгийн Батсайхан	125-1	18	196-1,197: нийгмийн хор аюулаар ялимгүй
16	024754	Ягааны Мөнхбаяр	112-2	25	6-1: тохирсон байсан
17	831618	Лувсанмөрийн Түдэв	123-3	19	6-1,196: хөөрөг хулгагсан нь тогтоогдоогүй
18	᠒᠐1266 28	Гонгорын Энхбаатар	124-3	17	196-1, 6-1:
19	024653	Лилмаагийн Намнансүрэн	98-1	17	6-4,196-2,197: талууд эвлэрсэн

Хүний эрхийг хангах зорилгоор прокурорын байгууллага хяналт хэрхэн тавьж байгаа, мөн өмгөөлөгчид ямар байдлаар оролцож байгааг үзвэл хяналтын прокурор нь хэрэгсэхгүй болгосон хэргийн материалуудтай бүрэн танилцсан байна гэж хэлж болно. Гэхдээ сэжигтнээр албадан саатуулах протоколын дийлэнхэд тухайн хүнд өмгөөлөгч авах эрхээр хангагдсан эсэх, түүнийг хэдийд чөлөөлсөн тухай ямар нэг тэмдэглэл алга. Мөн олон тооны протокол дээр прокуророос ямар нэг тэмдэглэл хийгээгүй учраас прокурорын өдөр тутмын хяналтын үр дүнг дүгнэхэд боломжгүй байна. Ялангуяа, дээр заасан 2000 оны 87 холбогдогчийн 57 нь, 2001 оны 24 холбогдогчийн 13 нь зөвхөн албадан саатуулагдаж байсан нөхцөлд үүнд прокуророос тавьсан хяналт хэргийн материалаас ойлгомжгүй байгаа нь зохисгүй байна.

Хоёр. Төмөр зам дахь Цагдаагийн хэлтэст хийсэн шалгалтын талаар

Тус хэлтсийн дарга Энхсайхан, орлогч дарга Отгонбат, МБТ-ийн дарга Догмид, Мэдээлэл, дүн шинжилгээний ахлах төлөөлөгч Энхбаяр нартай уулзаж, мөрдөн байцаалтын шатанд хэрэгсэхгүй болгосон хэргүүдийн материалтай танилцав.

Танилцсан хэргийн материалаас үзэхэд мөрдөн байцаалтын явцад 2000 он болон 2001 оны нэгдүгээр улиралд хэрэгсэхгүй болгосон хэрэгт сэжигтнээр албадан саатуулсан, сэжигтнээр цагдан хорьсон болон яллагдагчаар цагдан хорьсон хүний тоо, хэргийг хэрэгсэхгүй болгосон эрх зүйн үндэслэлийг хүснэгтээр үзүүлэв. Үүнд:

<i>Асуулт</i>	<i>2000 он</i>	<i>2001 он</i>	<i>Бүгд</i>
Танилцсан хэргийн тоо:			
мөрдөн байцаалтаар хэрэгсэхгүй болсон хэрэг	93	19	112
хэрэг бүртгэлтээр хэрэгсэхгүй болсон хэрэг	22	16	38
Эдгээр хэрэгт холбогдсон нийт хүний тоо	132	37	169
Хэрэгт холбогдсон хүмүүсээс сэжигтнээр албадан саатуулагдсан, цагдан хоригдсон хүний тоо	18	4	22
<i>Үүнээс:</i>			
Хэрэг нь ЭБШХ-ийн 6.1-ээр хэрэгсэхгүй болсон хүний тоо	14	1	15
Хэрэг нь ЭБШХ-ийн 196.2-оор хэрэгсэхгүй болсон хүний тоо	0	0	0
ЭХ-ийн 127-р зүйлд заасан хэргээр	2	0	2

Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтаар хэрэгсэхгүй болсон 2000 оны 132 холбогдогчтой 115 хэргийн материал үзэхэд 18 хүн (холбогдогчдын 13.6 хувь), 2001 оны 37 холбогдогчтой 35 хэргийг үзэхэд 4 хүнийг (10.8 хувь) албадан саатуулж, цагдан хорьсон нь Баянгол дүүргийн цагдаагийн хэлтэстэй харьцуулахад хэд дахин бага байна.

Хэрэгсэхгүй болгосон хэргийн материалаас үзэхэд 14-өөс дээш хоногоор албадан саатуулсан ба цагдан хорьсон хүн 2000 онд 3, 2001 онд 1 байна. Үүнд:

№	Хэргийн №	Хоригдсон хүн	ЭХ-ийн зүйл	Хоног	Хэрэг хэрэгсэхгүй болсон ЭБШХ-ийн үндэслэл
1.	822780	Цэдэнгийн Батжаргал	123-2	42	6-1,197:холбогдолгүй байх тул
2.	20022439	Далхжавын Отгонтөмөр	127-1	16	6-1,197: 1000 шил архи авсан нь залилан мэхлэх гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, иргэний журмаар
3.	027068	Лхагвасүрэнгийн	213	60	6-1,197: гэмтхэргийн бүрэлдэхүүнгүй
4.	20022475	Очирданзан Энхбат	265-1	14	6-1:

Прокурор болон өмгөөлөгч нараас хяналт тавьж байгааг үзэхэд Сэжигтнээр албадан саатуулах протоколд өмгөөлөгч авах эсэх, албадан саатуулагдсан хүн хэдийд чөлөөлөгдсөн тухай тэмдэглэл хийдэггүй нь нийтлэг байна. Гэхдээ хяналтын прокурор нь хэрэгсэхгүй болгосон бүх хэргийн материалтай танилцсан байна.

Илтгэх хуудсанд Судалгааны хүснэгт 31 хуудас материал хавсаргав.

ИЛТГЭХ ХУУДАС

2001.04.19.

Улаанбаатар хот

Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтэст судалгаа хийсэн тухай

Баянзүрх дүүргийн Цагдаагийн мөрдөн байцаах тасаг, Хэрэг бүртгэх албанд 2000 он, 2001 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэргүүдийн талаарх судалгааг Комиссын даргын баталсан удирдамжийн дагуу 2001 оны 4 -р сарын 16 -наас 18 -ны өдрүүдэд хийж гүйцэтгэв.

Тус дүүргийн цагдаагийн байгууллагад 2000 онд нийт 167 эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болгосноос 94 нь хэрэг бүртгэлтийн шатанд, 73 нь мөрдөн байцаах шатанд тус тус оногдож байна.

Хэрэг бүртгэлтийн шатанд хэрэгсэхгүй болгосон 94 хэргээс 93 нь Эрүүгийн хуулийн 86¹ зүйл ангиар эрүү үүсгэгдсэн (хүн амины хэрэг), зөвхөн нэг нь 239¹ зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэгдсэн байна. Эдгээр хэргүүдийг хэрэг бүртгэлтийн шатанд шалгах явцад 2 хүнийг 3 - 12 хоногоор нийт 15 хоногхорьсон судалгаа гарч байна. Үүнд ОХУ -ын иргэн Былиновский Владимир Геннадевич цуг архи ууж байсан эмэгтэй нь гэнэт нас барснаас 86¹ зүйл ангиар хүн амины хэрэгт сэжиглэгдэж 12 хоног, Баянзүрх дүүргийн иргэн Гарамжав овогтой Цэрэндэндэв иргэн Сарангэрэл осгож нас барсан хэрэгт холбогдож 3 хоног тус тус хоригджээ.

Мөрдөн байцаах шатанд 2000 онд хэрэгсэхгүй болгосон 86 хүнд холбогдох 73 хэргээс 37 нь гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй, 26 нь яллагдагч хохирогч нар хоорондоо эвлэрсэн, 5 нь иргэний журмаар шүүхээр шийдвэрлүүлэх, үлдэх 5 нь бусад үндэслэлээр хэрэгсэхгүй болгогдсон байна. Дээрх 73 хэргээс 27 хэргийн сэжигтэн, яллагдагчаар холбогдогчид 1 хоногоос 7 сарын хугацаанд тус тус хоригдон шалгагдаж байжээ. Эдгээрээс 11 хэрэгт холбогдох 12 хүн хоорондоо эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэгдэхгүй болгосноос бусад 16 хэргийн 18 хүнд үндэсгүйгээр хэрэг тулгаж хилсээр хорьж байжээ гэж үзэж болохоор байна.

Энэхүү 18 хүн 1 хоногоос 7 сарын хугацаанд буюу ойролцоогоор нийт 337 хоног хоригдож байснаас зарим анхаарал татсан хэргүүдийг дурдвал :

1. Эрүүгийн 931002 хэрэгт холбогдох Виктор овогтой Мөнхжаргал хулгайн хэрэгт холбогдон 123² зүйл ангиар ял сонсон 19 хоног
2. Эрүүгийн 930599 хэрэгт холбогдох Жамъянням овогтой Николай Эр[^]/гийн хуулийн 138¹ зүйл ангиар 19 хоног
3. Эрүүгийн 025925 хэрэгт холбогдох Хаш - Эрдэнэ овогтой Зул - Эрдэнэ 123¹ зүйл ангиар 30 хоног
4. Эрүүгийн 025989 хэрэгт холбогдох Намсрай овогтой Оюундоо 127¹ зүйл ангиар 3 хоног /хожим нь иргэний журмаар шийдэх хэрэг гэж хэрэгсэхгүй болгосон/

5. Эрүүгийн 930697 хэрэгт холбогдох Раашням овогтой Лувсандонров 127³ зүйл ангиар 2 хоног /иргэний журмаар шийдвэрлэх/
6. 026130 хэрэгт холбогдох Мөнхжин овогтой Дэмбэрэлдовдон 127¹ зүйл ангиар 3 хоног /иргэний журмаар шийдэх/
7. 026534 хэрэгт холбогдох ялтан /хоригдол/ Дамдин овогтой Баттөр, Дорж овогтой Ганзориг нар 239² зүйл ангиар 7 сар тус тус үндэслэлгүй хоригдож байжээ.

2001 оны эхний улирлын байдлаар хэрэг бүртгэх шатанд нийт 14 хэрэг хэрэгсэгдэхгүй болсноос 20131605 дугаарын хэрэгт холбогдох Хад овогтой Эрдэнэчулуун Эрүүгийн хуулийн 86¹ зүйл ангиар сэжиглэгдэн 3 хоног албадан саатуулагдсан, бусад 13 хэрэгт хэн нэгнийг хорьж шалгаагүй байв. Харин мөрдөн байцаах шатанд нийт 19 хэрэг хэрэгсэхгүй болгосноос 7 хэргийн 9 хүнийг 1 - 15 хоног нийт 58 хоног хорьж шалгаж байсан байна. Үүнээс хоорондоо эвлэрсэн үндэслэлээр зөвхөн 2 нь хэрэгсэгдэхгүй болж, үлдэх 7 хүн нь 1 - 15 хоног хилсээр хоригдож, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй гэсэн үндэслэлээр хожим хэргийг нь хэрэгсэхгүй болгож байжээ. 2001 оны эхний улиралд иргэний журмаар шийдвэрлэх хэрэгт хэдийгээр хүн хориогүй боловч 127 -р зүйл ангиар 3 хэрэг үүсгэн хожим нь хэрэгсэхгүй болгосон байна.

Баянзүрх дүүргийн Цагдаагийн хэлтсийн тоо бүртгэлийн алба болон мөрдөн байцаах тасгийн тоо бүртгэлд хэдэн хүн эрүүгийн хэрэгт холбогдон үндэслэлгүй хоригдсон тухай мэдээ байдаггүй байна. Энэ нь гэмт хэрэгт хүнийг үндэслэлгүйгээр хорьсон явдалд цагдаагийн удирлага, шүүх, прокурорын зүгээс хяналт тавих боломжгүй болгож цаашид уг үзэгдлийг давтан гаргах нөхцлийг бүрдүүлж байна гэж үзэж болохоор байна. Иймд хорьсон хүн болгоны тухай мэдээллийг тоо бүртгэлд тодорхой тусган үндэслэлгүйгээр хүн хорьсон холбогдох албан тушаалтанд хариуцлага тооцож байх журам тогтоон мөрдүүлэх нь зүйтэй гэсэн санал оруулж байна.

Шалгалт, судалгааны тухай танилцуулга

Монгол Улсын Хүний Эрхийн Үндэсний Комиссоос нэгдсэн удирдамжаар нийслэлд байдаг Цагдан хорих, албадан саатуулах, түр саатуулах байр, эрүүлжүүлэх байруудын нөхцөл байдал, хоригдогсодын эрхийн байдал ямар байгааг шалгаж, нийслэлийн зургаан дүүрэг, Төмөр замын цагдаагийн хэрэг бүртгэх, мөрдөн байцаах алба, Улсын мөрдөн байцаах газарт 2000 он болон 2001 оны эхний улиралд хэрэгсэхгүй болгосон эрүүгийн хэрэгт холбогдогсод авсан таслан сэргийлэх арга хэмжээний талаар судалгаа явуулав.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн биелэлт болон албадан саатуулах, цагдан хорих байр, эрүүлжүүлэх байрны нөхцөл байдал туйлын хангалтгүй байгаа, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус ажиллагаа, дураараа авирлалтын улмаас иргэдийн эрх, эрх чөлөө ноцтой байдлаар зөрчигдөж буй нь шалгалт, судалгаанаас харагдаж байна.

Нэг. Цагдаагийн Ерөнхий Газрын харьяа Цагдан хорих төвд (Ганц худаг)

хийсэн шалгалтын талаар

Шалгалтыг 200\$ оны 4 -р сарын 4, 5 -ны өдрүүдэд Прокурорын байгууллага, Эрүүл мэндийн улсын хяналтын албатай хамтарч, Цагдан хорих төвд очиж албан хаагчид болон хоригдогсодтой биечлэн уулзаж, санал хүсэлтийг нь сонсох, амаар болон бичгээр товч асуулга авах, хоригдогсодын хувийн хэрэг болон нэгдсэн тоо бүртгэл, мэдээг судлах, хорих байр, өрөө камерын нөхцөл байдлыг үзэж, ариун цэвэр, багтаамжийн үзлэг, хэмжилт хийх зэрэг аргаар явуулав.

Тус хорих төвийн эрэгтэйчүүдийг хорих байр нь 105 өрөөтэй, үүний 6 -д нь насанд хүрээгүй хүмүүсийг хорьдог. Эмэгтэйчүүдийн хорих байр нь 6 өрөөтэй.

Эрэгтэйчүүдийн хорих байрны арваас бусад хорих өрөөнд байгалийн гэрэл тусах цонхгүй, өрөөний хаалганы дээд хэсгээс ганц гэрэл ташуу байдлаар тусгасан, салхивч байхгүй, агааржуулах төхөөрөмж нь ажилладаггүйгээс агаарын солилцоо явагдах ямар ч боломжгүй, бие засах суултуурыг ил задгай байрлуулсан байна.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд зааснаар хорих өрөө нь цонхтой, салхивчтай байх ёстой атал байгалийн гэрэл тусдаггүй ба зохиомол гэрэл тааруугаас ном хэвлэл унших боломжгүй байна.

Хорих байрны подвалын хэсэгт 11.5 м^2 талбай бүхий нэг өрөөнд ихэвчлэн 7 - 9 хүнийг, бусад давхрын өрөөнүүдэд 12 хүртэлх хүнийг хорьж байгаагаас үзэхэд нэг хүнд ойролцоогоор $1,1\text{ м}^2$ - $1,6\text{ м}^2$ талбай ногдож байгаа нь хуульд заасан талбайгаас даруй $0,9\text{ м}^2$ - $1,4\text{ м}^2$ -аар бага байна.

Гуравдугаар давхрын 3 тоот өрөөнд 12 хүүхэд хоригдож, нэг хүүхдэд 0, 66 м^2 талбай ногдож байгаа нь агаарын солилцоо явагддаггүй орчинд насанд хүрээгүй хүний эрүүл мэндэд ямар аюултай байх нь мэдээж.

Бүх өрөөнүүд цементэн шалтай ба модон наарыг зохих ёсоор хийсэн өрөө тун цөөхөн, ихэвчлэн цементэн шалан дээр модон шалны шаардлага хангахгүй хоорондоо завсар зай бүхий хэдэн банзыг нийлүүлж хадаад тавьсан байна.

7- 9 хоригдогсдын дунд 3-5 гудас, 5-6 нөмрөг (бүтээлэг) ноогддог ба ихэнх хоригдогсод хувийн ариун цэврийн наад захын хэрэглэлгүй, оо, шүдний сойз, саванг дундаа хэрэглэдэг байна.

Усны хангамж туйлын хангалтгүй, өдөрт хсёр удаа ус өгдөгөөс чөлөөтэй бие засах боломжгүй, хоригдогсод цангаагаа гаргах, ариун цэврийн хэрэгцээгээ хангахын тулд жорлон руу орсон цоргоноос ус авч гялгар уутанд нөөцөлдөг байна.

Эмэгтэйчүүдийг тусдаа нэг давхар байранд хорьдог ба $8,4\text{ м}^2$ - $8,8\text{ м}^2$ талбай бүхий 6 өрөөтэй, хуульд заасны дагуу уг байр нь 21 хүний багтаамжтай байхад шалгалтын үед (4-р сарын 4-ний өдөр) 70 эмэгтэй хоригдож байснаас үзэхэд дунджаар нэг хүнд $0,7\text{ м}^2$ талбай ногдож байсан нь байх ёстой хэмжээнээс даруй 3 дахин бага байв.

Эмэгтэй хоригдогсод нь тусдаа бие засах газар, ариун цэврийн өрөөтэй бөгөөд өдөрт зөвхөн хоёр удаа нэгдсэн журмаар бие засаж, бусад үед нь өрөөндөө хувинд бие засаж, зөөж асгадаг байна.

Мөн байр нь цонхгүй, агааржуулах төхөөрөмжгүй бөгөөд хаалганы дээд хэсгээс нэг чийдэн тавьснаар гэрэлтүүлэг нь хязгаарлагдаж буй тул өдөр ном сонин унших боломжгүй шахам байна.

Хүн нэг бүрт тухайлсан хучлага, дэвсгэр байдаггүй, өгсөн хучлага, дэвсгэр нь хүрэлцдэггүй тул шөнөдөө даарч хонодог тухай эмэгтэйчүүд гомдол мэдүүлж байв.

Насанд хүрээгүй хүмүүсийг эрэгтэйчүүдийн хорих байранд тусад нь 6 өрөөнд хувиарлаж, адил нөхцөлд хорьж байна.

2001 оны 4 -р сарын 4 -ний өдрийн байдлаар тус хорих төвд нийтдээ 793 хүн хоригдож

байснаас 619 нь мөрдөн байцаалтанд, 117 нь шүүхийн шатанд, 57 нь уг төвийн аж ахуйн ажилд ялаа эдлэгсэд байлаа.

52 хүн зургаан сараас дээш, зарим нь хоёроос дөрвөн жил хүртэл хугацаагаар хоригдож байгаа бөгөөд мөрдөн байцаалтын шатанд хоригдогсдын 80 орчим хувь нь өмгөөлөгч аваагүй, өмгөөлөгчтэйгөө нэг ч удаа уулзаагүй байлаа.

Шалгалтын үед Д. Батболд, С. Бямбаа, Э. Батцагаан нарын 15-17 насны гурван хүүхдийг сахилгын өрөөнд насанд хүрэгчидтэй хамт, сүрьеэ өвчтэй, хэвтэрт орсон Г. Эрдэнэбат гэгчийг нийтийн өрөөнд хамт хорьж байв.

Лабораторын шинжилгээгээр Цагдан хорих төвийн өрөөний 1 м³ агаарт байх нянгийн тоо эрүүл ахуйн нормоос хоёроос дөрөв дахин их, цус задпагч стафилоккокк нян эрүүл ахуйн нормоос 7,2 дахин их байгаа ба шинжилгээ авсан өрөөнүүдийн агаарт хөгц илэрсэн байна.

Эдгээрээс үзэхэд гэмт хэрэгт холбогдон сэжигтэн, яллагдагчаар татагдан хоригдогсдын хуульд заасан эрх, эрх чөлөө ноцтойгоор зөрчигдөж, энэ нь олон жилээр үргэлжлэн, төрийн холбогдох байгууллага, албан тушаалтнууд ийм байдалд нүд, сэтгэл дасаж, улам архагшин даамжирсаар байна.

Энэ талаар гарсан дараах хуулиудын тодорхой заалтуудыг амьдралд ажил хэрэг болгох шаардлага хурцаар тавигдаж байна.

Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд:

- Хоригдсон этгээдийн байрлах өрөө нь . . . цонх нь төмөр сараалжин хамгаалалттай, агааржуулах салхивчтай, модон шалтай, эсхүл модон наартай байх бөгөөд хорих өрөөний чийглэг 55 - 60 хувь . . . , хорих байр нь агааржуулах төхөөрөмжтэй байна.
- Хоригдсон этгээд нь өөрийн аюулгүй байдлыг хангуулах, өмгөөлөгчтэйгөө уулзах, хууль зүйн туслалцаа авах, 2200 килокалориас дээш хэмжээний илчлэгтэй хоол, дэвсгэр, хучлагаар хангагдах, захидалцахилгаанаар харилцах, бичгийн хэрэглэл ашиглах, боловсрол мэдлэгээ дээшлүүлэх, шаардлагатай сурах бичиг, ном ашиглах.
- Хоригдсон этгээд нь ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагад тохирсон нөхцөл, унтаж амрах боломжоор хангагдаж, нэг хүнд 2,5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ноогдох ба хорих байрны захиргаа нь хоригдсон этгээдийн эрүүл мэндийг хамгаалахуйц ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангах үүрэгтэй.
- Хоригдож байгаа насанд хүрээгүй этгээдийг ахуй нөхцлийн хувьд сайжруулсан

байранд байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлж, тэднийг өдөр тутмын салхинд гаргах хугацаа нэг цаг ба түүнээс дээш байна.

- Хоригдож байгаа жирэмсэн эмэгтэйг ахуй нөхцлийн хувьд сайжруулсан байранд байлгаж, эмчийн хяналтанд байлгаж, түүнд өгөх хоолны илчлэгийн хэмжээг нэмэгдүүлнэ. Түүний өдөр тутмын салхинд гарах хугацаа нэг цаг ба түүнээс дээш байна.

Эрүүгийн байцаан шийтгэх хуульд :

- Хэрэг бүртгэх байгууллага, мөрдөн байцаагч нь сэжигтэн, яллагдагчийг өмөөлүүлэх бололцоогоор хангах, түүний хувийн болон эд хөрөнгийн эрхийг хамгаалах талаар хуульд заасан арга хэмжээ авах үүрэгтэй. - гэж заасан.

Хоёр. Албадан саатуулах байруудад (72 цагийн саатуулга) хийсэн шалгалтын талаар

Улаанбаатар хотод байдаг хоёр албадан саатуулгын байр.тухайлбал Нийслэлийн Цагдаагийн Газрын харъяа албадан саатуулах байр, Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн албадан саатуулах байрны нөхцөл, саатуулагсдын эрхийн байдал ямар байгааг шалгаж судалгаа хийв.

2000 онд тус хоёр албадан саатуулах байранд 11094, 2001 оны эхний улиралд 3011 хүнийг албадан саатуулжээ.

Хүмүүсийг үндэслэл муутайгаар албадан саатуулдаг, прокурорт хуульд заасны дагуу мэдэгддэггүй, хоол ундыг нормын дагуу өгдөггүй, хучлага, дэвсгэр өгдөггүй, салхинд гаргадаггүй, агааржуулалт, салхивч байдаггүй зэрэг нийтлэг дутагдал байгаагийн зэрэгцээ хүнийг олон цагаар хорьж саатуулахад, түүний эрүүл мэндэд ноцтой хохирол учирахуйц нөхцөл байдал их байна.

Тухайлбал, Баянзүрх дүүргийн албадан саатуулгын өрөөнүүд нь подвалд байрладаг бөгөөд нийтдээ долоон өрөөтэй, байгалийн гэрэл тусдаггүй, зөвхөн хаалганы дээд хэсгээс ганц чийдэн асаалттай байдаг, агаарын солилцоо явагдах ямар ч боломж байхгүйн улмаас өрөөнүүдээс маш эвгүй үнэр ханхалж, их бүгчим байв.

Нийт долоон өрөөний талбай 59,5 м² бөгөөд хуульд зааснаар дээд тал нь 23 хүн хорьж болох байхад шалгалт хийсэн өдөр 51 хүн хоригдож байв. Нэг хүнд дунджаар 1,1 м² талбай ноогдож байна.

39 хүнийг саатуулсан протокол дээр прокурор танилцаж, гарын үсгээ зураагүй, саатуулагдсан бүх

хүн өмгөөлөгч аваагүй, өмгөөлөгч авдагыг ч

мэдцэггүй, 20 гаруй хүний ар Гэрт мэдэгдсэн зүйлгүй байлаа. Яагаад өмгөөлөгч аваагүй тухай асуухад тэр тухай хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч тайлбарлаж өгөөгүй гэж ярьж байв.

Баянзүрх дүүргийн албадан саатуулах байранд ямар ч хучлага, дэвсгэр өгдөггүй байна.

Шинжилгээгээр тус байрны агаарт байх нянгийн тоо эрүүл ахуйн нормоос дөрөв дахин их байна.

Гурав. Нийслэлийн төвийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүд. Төмөр замын цагдаагийн хэлтсийн түр албадан саатуулах (6 цагийн) байранд

хийсэн шалгалтын талаар

Бүх дүүргийн цагдаагийн байруудаас гадна Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтсийн харъяа “Нарантуул” зах, Хан - Уул дүүргийн цагдаагийн хэлтсийн харъяаны Яармаг болон Нисэх буудлын орчимд түр саатуулах байр байна.

Саатуулах байрууд нь ихэвчлэн ямар ч цонх, гэрэл гэгээ байхгүй, цементэн шалтай, халаалтгүй, суух сандалгүй, багтаамж муутай байна.

Зөвхөн 2001 оны эхний улиралд дээрх байрнуудад 7595 хүнийг албадан саатуулсан байгаа бөгөөд хуульд зааснаар гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн этгээдийн нэр, хаягийг тодруулах, албадан саатуулах үндэслэл байгаа эсэхийг тогтоохын тулд уул этгээдийг зургаан цаг хүртэлх хугацаагаар түр саатуулах ёстой байхад цагдаагийн ажилтнууд хэнийг ч ялгалп/й саатуулж, хүний эрхийг зөрчиж буйн зэрэгцээ, саатуулсан хүнийг зургаагаас дээш олон цагаар, заримдаа хонуулах, бүртгэлд бүртгэхгүй хорих, түр саатуулах байранд орсон цаг, гарсан цагийг санаатайгаар тэмдэглэхгүй орхисны улмаас тухайн хүн хэдэн цаг хоригдсон нь мэдэгдэхгүй үлдэх зэрэг хууль бус ажиллагаа хавтгайран гарч байна.

Түүнчлэн түр саатуулах байранд иргэдийг саатуулах ямар нэг журам байхгүй, хэн ч хяналт тавьж, тооцоо судалгаа хийдэгп/й, цагдаагийн хэлтсийн дарга нар дуртай газраа түр саатуулах байрыг нээж ажиллуулдаг 'зэрэг нь хүний халдашгүй байх эрхийг бүдүүлгээр зөрчиж буйн илрэл болж байна.

Дөрөв. Нийслэлийн дүүргүүдийн цагдаагийн хэлтсүүдийн эсүүлжүүлэх байруудад хийсэн шалгалтын талаар

Нийслэлийн төвийн бүх дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн болон Төмөр замын цагдаагийн хэлтсийн эрүүлжүүлэх байруудад сүүлийн гурван жилд 169923 хүн, энэ оны эхний улиралд 18333 хүн эрүүлжүүлэгдсэн тооцоо гарч байгаа бөгөөд нийтдээ 371 сая төгрөгний хураамжийг

эрүүлжүүлэгдсэн хүмүүсээс хурааж авсан байна.

Үүнээс маш олон тооны хүн эрүүлжүүлэгдцэг, их ч хэмжээний орлогыг цагдаагийн байгууллагууд олдог нь харагдаж байгаа боловч иргэдийн хууль ёсны эрх зөрчигдөж, эрүүлжүүлэх ажиллагааны явцад цагдаагийн ажилтнууд эрх мэдлээ урвуулан ашигладаг, зарим эрүүлжүүлэх байрны нөхцөл туйлын хангалтгүй, төрийн байгууллага өнөөдөр хүнийг тийм байранд байлгаж байгаа нь хүний алдар хүнд, эрүүл мэндэд төдийгүй төрийн өөрийн нэр хүндэд ноцтой хохирол учруулах муу үр дагавартай байна.

Хэдийгээр хотын гудамжаар согтуу хөлчүү хүмүүс олон нийтийн амгалан тайван байдлыг алдагдуулж, танхайрч байгаа нь үнэн бөгөөд тэдэнтэй тэмцэл хийж эрүүлжүүлэх арга хэмжээ авах нь зөв боловч, өнөөгийн арга барилаар, кампаничилсан байдлаар, ийм арчаагүй байр ашиглан, зөвхөн хонуулсан нэр зүүж, хүмүүсээс хэдэн төгрөг салгаж авах замаар цааш ажиллах боломжгүй болжээ.

Сүхбаатар, Баянзүрх, Хан - Уул дүүргийн эрүүлжүүлэх байрнууд нь байшингийн подвалд байрладаг Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийнх агааржуулалт, гэрэлтүүлэг байхгүй, үмхий ханхалсан, шүршүүр, гар нүүр угаах тосгуур ч байхгүй, хордлого тайлах, эрүүлжүүлэх ямар ч үйлчилгээ хийдэггүй атлаа хүргэгдэж ирсэн бүх хүнээс усанд оруулсан, эмч үзсэн, хувцас тайлсан, утсаар ярьсан, замын зардалд гэж 4500 төгрөг хураан авч байна.

Сүхбаатар дүүргийн цагдаагийн эрүүлжүүлэх байр нь ямар ч гэрэлтүүлэг, цонх агааржуулалтгүй, чийг, шивтэр ханхалсан 26,7 м² талбай бүхий дөрвөн өрөөтэй ба 2001 оны 4 -р сарын 4 -ний шөнө (шалгалт хийсэн өдрийн) 45 хүн хоносон бөгөөд нэг хүнд 0,59 м² талбай ноогдож байв. Уг байр нь мөөгөнцөр ургасан, засал хийгээд тордлого авахаа байсан, үнэхээр хүн жигшмээр болсон байр юм.

Шинжилгээгээр тус эрүүлжүүлэх байрны 1 м³ агаарт байх нянгийн тоо эрүүл ахуйн нормоос дөрөв дахин их, цус задлагч стафилококк эрүүл ахуйн нормоос мөн дөрөв дахин их гарч байна.

Сүхбаатар дүүргийн эрүүлжүүлэх байрнаас сүүлийн гурван жилд 49,2 сая төгрөгний орлого олсон байхад, дөрвөн өрсөнд ганц ширхэг чийдэн тавиад гэрэлтүүлчихэж чадаагүй байна.

Сүүлийн гурван жилд эрүүлжүүлэх байруудад дөрвөн хүн нас баржээ.

Хоногийн зардал гэх 4500 төгрөгийг төлөх боломжгүй хүмүүсээр Сүхбаатар, Сонгинохайрхан дүүргийн цагдаагийн байгууллага хонуулсны маргааш нь үргэлжлүүлэн албадан ажил хийлгэдэг байна.

Тав. Хэрэгсэхгүй болгосон хэргийн судалгааны талаар

2000 он болон 2001 оны эхний улиралд Мөрдөн байцаах газар, Нийслэлийн төвийн зургаан дүүргийн цагдаагийн хэлтэс, Төмөр замын цагдаагийн хэлтэс дээр хэрэгсэгдэхгүй болсон 2287 хүнд холбогдох эрүүгийн хэргийг судалж үзэхэд, сэжигтэн, яллагдагч гэж тооцогдож байсан 497 хүнийг 1 - 210 хоногоор албадан саатуулж, цагдан хорьсон байна.

Төв цагдан хориход шалгалт хийсэн 2001 оны 4-р сарын 4-ний өдөр урьдчилсан мөрдөн байцаалтын шатанд хоригдож байсан 619 хүний хүн нэг бүрийн хоригдсон үндэслэлийн талаар зөв, буруу гэж хэлэх боломжгүй боловч энэхүү судалгааны дүн нь тодорхой таамаглал, дүгнэлт хийх боломжийг олгож байна.

Зургаа. Шалгалтын мөрөөр авсан арга хэмжээний талаар

1. Хийсэн шалгалтын талаар тухайн байгууллагын удирдлага, холбогдох ажилтнуудад газар дээр нь хэлж танилцуулж байсан бөгөөд, ЦЕГ - ын удирдлага, Цагдан хорих төвийн дарга, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн дарга, УМБГ -ын дарга, хэлтсийн дарга, дүүргүүдийн цагдаагийн хэлтсийн мөрдөн байцаах тасгийн дарга нарыг байлцуулан танилцуулга хийв.

2. а\ Оршиж байгаа дутагдлыг арилгуулах, тухайлбал Цагдан хорих төвд хуульд заасан 2,5 м² талбайд нэг хүнийг хорьж байх, насанд хүрээгүй хүн, жирэмсэн эмэгтэйд өдөрт нэг цагаас багагүйгээр салхилуулдаг болох, хоригдогсад бүрт хучлага, дэвсгэр өгөх, хорих байрны подвалын жижиг цонхуудыг салхивчтай болгох, усан хангамжийг сайжруулах шаардлагыг албан ёсоор тавив.

Шинээр барьж байгаа хорих байрны өрөө болгонд цонх (салхивчтай) гаргах, модон шалтай болгох шаардлагыг мөн тавив.

Түүнчлэн албадан саатуулах байр, эрүүлжүүлэх байрыг байшингийн подвалд харанхуй орчинд байршуулдаг хоцрогдсон хандлага, арга барилыг халах, бүх байруудад цонх, салхивч гаргах, зөвхөн хуульд заасан даацынхаа хэмжээгээр хүн хүлээж авдаг байх, хүн болгонд тухайлсан хучлага, дэвсгэр олгож байх, хоол ундны хангамж, ариун цэврийн нөхцөл байдлыг сайжруулах шаардлага тавьсан.

Баянзүрх дүүргийн цагдаагийн албадан саатуулах байрны нөхцөлийг энэ оны 6 -р сарын 15-ны дотор хуульд заасны дагуу бүрдүүлэх шаардлагыг тавив.

б\ Эрүүл ахуй, ариун цэврийн наад захын шаардлага хангахгүй байгаа Сүхбаатар дүүргийн эрүүлжүүлэх байрыг 2001 оны 4-р сарын 30-наар тасалбар болгон хаалгах, эрүүлжүүлэх байруудыг салхивч, агааржуулалт, шүршүүр, хордлого тайлдаг үйлчилгээтэй болгох, хүмүүсээр албадан ажил хийлгэдэг хууль бус ажиллагааг таслан зогсоох, хүн бүрээс 4500 төгрөг авч хохироодог явдлыг зогсоож, үнэхээр үзүүлдэг үйлчилгээндээ тохируулж төлбөр авч байхыг

шаардаж, зөвлөмж өглөө.

в\ Түр саатуулгын өрөөнүүдэд ямар ч хяналтгүйгээр, хэнийг ч хамаагүй саатуулж улмаар олон цагаар хэтрүүлэн хорьж байгааг таслан зогсоох, нэгдсэн журам тогтоох, хяналт тооцоо бүртгэлийг сайжруулах, уг өрөөнүүдэд цонх, салхивч гаргаж, сандал тавих, модон шалтай болгох шаардлагыг тавьсан.

Эдгээртэй холбоотойгоор дараах саналыгтавьж байна

1. Цагдан хорих төвд баригдаж байгаа шинэ байрны өрөө бүрийг цонх, салхивчтай, модон шалтай, ариун цэврийн тусдаа өрөөтэй, подвалыг нь хүн хорих зориулалтгүй, үйлчилгээний хэсэг болгох арга хэмжээ авах

2. Цагдан хорих төв, аймгуудын хорих байр, албадан саатуулах байр, түр саатуулалтын өрөөнүүдийг Сэжигтэн, яллагдагчийг албадан саатуулах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд заасан стандарт, шаардлагад нийцүүлэн тоноглож засварлах ажлыг 2001 оны III улиралд багтааж хийх

3. Хүнийг үндэслэлгүйгээр саатуулж, хорьж цагддаг хууль бус ажиллагааг таслан зогсоох, буруутай этгээдүүдтэй хариуцлага тооцдог журам тогтоох, шинээр боловсрогдож байгаа Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хүнийг гэмт хэрэгт сэжиглэн албадан саатуулах, цагдан хорих асуудалд туйлын нарийн шалгуур тогтоож өгөх

4. Эрүүлжүүлэх байрны өнөөгийн тогтолцоог эргэн харж, зайлшгүй байх шаардлагатай гэж үзвэл, цагдаагийн байгууллагын харъяанаас гаргаж, эрүүл мэндийн байгууллагын харъяалалд өгөх асуудлыг судпан үзэж шийдвэрлэх.